

2-р ангийн Математикийн хичээлийн “Үржих үйлдлийн утга санааг ойлгуулах “ нэгж хичээл
Ээлжит хичээлийн төлөвлөлт

Сэдэв:- Хялбар аргаар тооцоолж сурах

Зорилго:- Хялбар аргаар тооцоолж сурцгаая.

Зорилт:- Бодит юмсыг багцлах

- Ижил нэмэгдэхүүнийг нийлбэрийг үржвэр хэлбэрээр бичих
- Үржүүлэх үйлдлийг ижил нэмэгдэхүүний нийлбэрээр бичих
- Үржүүлэх үйлдлийн гишүүдийг нэрлэх, таних

Хичээлийн явц:

Зохион байгуулалт:- Ангийг 4 багт хуваана

Үе шат	Багшийн дэмжлэг	Сурагчийн үйл ажиллагаа	Анхаарах зүйл
Сэдэлжүүлэлт	-Баг бүрт 8 шагай өгсөн байна. Ширээн дээр байгаа шагайгаа тэнцүү тоогоор хувааж тавиарай. Багцласнаа ижил нэмэгдэхүүний хэлбэрээр бичээрэй. Өөр хувилбар байна уу? Бүх хувилбаруудыг туршаад ижил нэмэгдэхүүний нийлбэр хэлбэрээр дэвтэртээ бичээд утгыг олоорой.	Сурагчид 8 шагайг багцлан тавих Ижил нэмэгдэхүүнүүдийн нийлбэр хэлбэрээр дэвтэртээ бичих Сурагчид санаагаа хэлнэ.	
Мэдлэг бүтээлэх	Баг бүрээс нэг сурагчийн санааг самбарт бичнэ. $2+2+2=$ $4+4=$ $1+1+1+1+1+1+1=$ Буруу ч байсан бичнэ. Хасах, нэмэх үйлдлийг тавьж болох уу? Хэд гарахыг ярилцах Үржүүлэх үйлдлийн тэмдгийг тайлбарлах . х Үржүүлэх үйлдлийн гишүүдийн нэрийг нэрлэх Унших аргыг тайлбарлан дагуулан унших Хоёр дөрөв найм.	Багшийн дэмжлэгтэй үржвэр хэлбэрээр хэрхэн бичихийг ярилцах Ямар тэмдэг байж болохыг ярилцах, санал бодлоо илэрхийлэх	
Бататгал	Дараах тоог ижил нэмэгдэхүүнүүдийн нийлбэр хэлбэрээр бичээрэй. $4*3=$ $6*5=$ $5*4=$ $2*9=$ Бодлого зохиолгох, тайлбарлуулах /Тарааж өгөх материал/	Бодлогоо бодож самбарт нааж тайлбарлана.	
Дүгнэлт	Ижлээ олъё тоглоом тоглох		
Гэрийн даалгавар	Сурах бичгийн хуудас 58 №3,4 Үржүүлэх үйлдлийн гишүүдийн нэрийг тогтоож ирээрэй.		

2-р ангийн Математикийн хичээлийн “Үржих үйлдлийн утга санааг ойлгуулах “ нэгж хичээл

Ээлжит хичээлийн төлөвлөлт \Сайжруулсан хөтөлбөр\

Сэдэв:- Хялбар аргаар бодох


Зорилго:- Хялбар аргаар тооцоолж сурцгаая.

Зорилт:- Бодит юмсыг багцлах


- Ижил нэмэгдэхүүнийг нийлбэрийг үржвэр хэлбэрээр бичих
- Үржүүлэх үйлдлийн гишүүдийг нэрлэх, таних

Хичээлийн явц:

Зохион байгуулалт:- Сурагчдыг 5 багт хуваана

Үе шат	Багшийн дэмжлэг	Т	Сурагчийн үйл ажиллагаа	Анхаарах зүйл
Сэдэлжүүлэлт	-Хоёр хүүхдийн дунд 8 шагай өгсөн байна. Хүүхдүүдээр шагайг тоолуулна. Шагайгаа тэнцүү тоогоор хувааж тавиарай. Багцласнаа ижил нэмэгдэхүүний нийлбэр хэлбэрээр бичээрэй. Өөр хувилбар байна уу? Бүх хувилбаруудыг туршаад ижил нэмэгдэхүүний нийлбэр хэлбэрээр дэвтэртээ бичээд утгыг олоорой.	3	8 байгааг хэлнэ. Сурагчид 8 шагайг багцлан тавих 	2+2=4 1+1=2 3+3+2=Ийм тохиолдлыг хүүхэд хэлбэл самбарт төлөвлөснөөр бичнэ.
		5	Ижил нэмэгдэхүүнүүдийн нийлбэр хэлбэрээр дэвтэртээ бичих 1+1+1+1+1+1+1+1= 2+2+2+2= 4+4= Сурагчид санаагаа хэлнэ.	Хянаад зөв бодсон тохиолдолд тамга дарах, алдаа гаргасан бол засаж залруулах, зөвлөх

Сурагчдын санааг самбарт бичнэ. нэмэгдэхүүн нэмэгдэхүүн нийлбэр $2 + 2 + 2 + 2 = 8$ үржигдэхүүн үржигдэхүүн үржвэр = 8 $4+4=8$ = 8 $1+1+1+1+1+1+1=8$ = 8 Хэлж бичихэд ямар байна, хэцүү байна ... Буруу ч байсан бичнэ./Самбар төлөвлөлт дээрээ бичих/ Олон ижил тоонуудыг бичиж нэмэхэд хугацаа их ордог, хүндрэлтэй байна уу?. Ижил нэмэгдэхүүнүүдийн нийлбэрийг хялбар аргаар олдог арга байдаг. Та нар тэр аргыг мэдэх үү? За тэгвэл өнөөдөр тэр аргыг мэдэж авъя. Зорилгоо самбарт байрлуулах Нэмэгдэхүүнүүдээ тоолъё. $2+2+2+2=8$ 4 2 = 8 Ямар тэмдэг тавибал болох вэ? Хэдэн ширхэг байна? Хаоюу ижил байна Хэдийн тоо байна вэ? Нэмэх тэмдгийг тавьж үзье. $4+2=6$ Хаоюу ижил байна үү? Хасах тэмдгийг тавьж үзье.Хэд гарахыг ярилцах $4-2=2$ /нэмэхтэй адил/ Өөр ямар тэмдэг тоо бодоход хэрэглэдэг вэ? Та нар мэдэр үү? Энэ тэмдгийг мэдэх үү? Үржүүлэх үйлдлийн тэмдгийг тайлбарлах . x Нэмэх үйлдлийн гишүүдийн нэрийг нэрлүүлнэ. Үржүүлэх үйлдлийн гишүүдийн нэрийг нэрлэх Унших аргыг тайлбарлан дагуулан унших Дөрвийг үржүүлэх нь хоёр тэнцүү найм – 2-3 удаа дагуулан уншуулна.	6 Багшийн дэмжлэгтэй үржвэр хэлбэрээр хэрхэн бичихийг ярилцах Ямар тэмдэг байж болохыг ярилцах, санал бодлоо илэрхийлэх Хүүхдүүд анхааралтай сонсох Дагуулж хэлж бичих, унших Хариу ижил байна гэдгийг ойлгож авна. Буруу байна гэдгийг хэлнэ. 4 2 = 8 Нэмэх, хасах тэмдэг тавьж болохгүй гэдгийг ойлгож авна. Хүүхдүүд үржүүлэх үйлдлийн тэмдэг гэж хэлж болно. $4 \times 2=8$ $2 \times 4=8$ $8 \times 1=8$ дэвтэрт бичигдэнэ. Хялбар аргаар бичилт хийж байна гэдгийг ойлгож авна. Нэмэгдэхүүн, нэмэгдэхүүн нийлбэр Үржигдэхүүн үржигдэхүүн үржвэр	$2+2=4$ $1+1=2$ $3+3+2=Ийм$ тохиолдлыг хүүхэд хэлбэл самбарт төлөвлөснөөр бичнэ. Тоо болон хүснэгтээ зайтай бичих. Сүүлд нь үйлдлийн гишүүдийн нэрийг байрлуулах учиртай. Хэрэв хэлэхгүй бол тулгуур дохио ашиглана. x Хэрчмэл хэлбэрээр бичигдсэн үйлдлийн гишүүдийн нэрийг дээрх бичиглэлд тохитуулан байрлуулна.
--	---	--

Бататгал	Баг тус бүрт зурагт үзүүлэн өгч ижил нэмэгдэхүүний нийлбэр болон хялбар аргаар тооцоолон бичээрэй. Багаараа ярилцаад ижил нэмэгдэхүүнүүдийн нийлбэр хэлбэрээр бичээд, хялбар аргаар бичих / Тарааж өгөх материал дээрээ бичих/	5	 Бодлогоо бодож тайлбарлаад самбарт байрлуулна.	
Дүгнэлт	Та нар тоглох дуртай юу? Тоглох уу? “Найзаа олъё” тоглоом тоглоё. Багш зааврыг сайтар өгөх. Эхлээд өөрт оногдсон материалыг ажиглана. Бүх хүүхэд ангид тойрог болж зогсоод бусдын барьсан материалыг ажиглаад өөрийн найзыг олно. Яагаад найзууд болсныг тайлбарлуулна. Найзуудын хэдэн баг үүссэн бэ?	10	     $2 + 2 + 2 =$ $3 \times 2 =$ Энэ 3 найз гэдгээ хайж олоод, самбарт байрлуулна.	Зааврыг сайтар өгөөгүйгээс бужигнах магадлалтай.
Гэрийн даалгавар		1	Сурах бичгийн хуудас 58 №3,4 Үржүүлэх үйлдлийн гишүүдийн нэрийг тогтоож ирээрэй.	

Самбарын төлөвлөлт

11 сарын 12

Хялбар аргаар тооцоолж сурцгаая.
ажилласан дасгал

Анхаарах зүйл:

$$2 + 2 = 4$$

$$\boxed{2} * \boxed{2} = 4$$

10

$$1 + 1 = 2$$

$$\boxed{1} * \boxed{1} = 2$$

$$3 + 3 = 9$$

$$4 + 2 = 6$$

$$= 9$$

$$4 - 2 = 2$$

Хялбар аргаар бодох

Нэмэгдэхүүн нэмэгдэхүүн нийлбэр

$$2+2+2+2=8$$

Үржигдэхүүн Үржигдэхүүн үржвэр

$$\boxed{4} * \boxed{2} = 8$$

$$1+1+1+1+1+1+1+1=8$$

$$\boxed{8} * \boxed{1} = 8$$

$$4 + 4 = 8$$

$$\boxed{2} * \boxed{4} = 8$$

Багаар



+



$$5 + 5 =$$

$$2 * 5 =$$



+



+



$$3 +$$

$$3 * 3$$




3-р багт өгсөн даалгавар

4-р багт өгсөн даалгавар

Үргэлжлэл

Найзаа олъё

Жич: Нэг багт багийн гишүүдийн тоогоор доорх тарааж өгөх материалуудыг өгч ажиглуулан, найзуудыг олуулна. Зурган даалгавар 2, нэмэгдэхүүний нийлбэр болгон задалсан даалгавар 2, үржвэр хэлбэрээр бичсэн даалгавар 2 гэх мэт тарааж өгнө. Зурган даалгаврыг эхний хоёр даалгаврын жишгээр хийнэ. Ангийн бүх хүүхэд оролцох ёстойг анхаарна уу.

			5,5-аараа багцалсан доорх зураг 4 байна. 8,8-аараа багцалсан дээрх зураг 4 байна. 	 9, 9-өөрөө багцалсан дээрх зураг 3 байна.
$3 + 3 =$	$2 + 2 + 2 =$	$8+8+8+8=$	$5 +5+5+5=$	$9+9+9=$
$2 * 3$	$3 * 2 =$	$4 * 8 =$	$4* 5 =$	$3 * 9 =$

=				
---	--	--	--	--